

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
2016 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг тус тус баримтлан 2016 оны III дугаар улирлын байдлаар тус яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг гаргав.

Нэг. Засгийн газар иргэдээ шууд сонсох, санал хүсэлт хүлээн авах чиг үүрэг бүхий 11-11 төвөөр дамжуулан Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 30-ныг хүртэлх хугацаанд нийт 1926 хандалт бүртгэгджээ.

2016 оны III улиралын байдлаар иргэдээс ирүүлсэн дээрх хандалтуудын 1893 хаагдсан, 30 нь судлагдаж байгаа ангилалтай байна. Хариуг 98.28 хувь өгсөн бөгөөд санал хүсэлтийг ангилж үзвэл:

д/д	Төрөл	Тоо
1.	Санал хүсэлт	1350
2.	Гомдол	373
3.	Шүүмжлэл	193
4.	Талархал	9
5.	Өргөдөл	2
Нийт		1926

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 оны III дугаар улирлын байдлаар иргэдээс нийт 410 өргөдөл, хүсэлт ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 360, шийдвэрлэхээр судлан хяналтад байгаа 39, хуулийн хугацаа нь болоогүй 11 өргөдөл байна.

2016 оны III дугаар улирлын байдлаар иргэдээс хандаж
ирүүлсэн өргөдөл, гомдол санал, хүсэлт

Д/д	Яам, агентлагийн нэрс	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Бусад хэлбэрээр
1.	Зам, тээврийн хөгжлийн яам	410	410	1926	-	-
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	600	600	-	-	-
Нийт		1010	1010	1926	-	-

Зам, тээврийн хөгжлийн яамны 2016 оны III дугаар улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

д/д	Яам, агентлагийн нэрс	Ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт
1.	Зам, тээврийн хөгжлийн яам	410	365	15	10	89,02 %
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	600	556	-	44	92,66 %
Нийт		1010	916	15	55	90,69 %

2016 оны III дугаар улирлын байдлаар ирүүлсэн өргөдөл гомдолд зонхилж тавьсан асуудал

Д/д	Яам, агентлагийн нэрс	Агуулга
1.	Зам, тээврийн хөгжлийн яам	Иргэдээс ирсэн нийт 410 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс 77,31 % буюу 317 өргөдөл үйл ажиллагаатай холбоотой хүсэлт, 22,68 % буюу 93 өргөдөл тэтгэмж туслалцаа, ажилд орох, гарах, тэмдэг нөхөн олгуулах хүсэлт зонхилж байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Ажилд орох, гарах, чөлөө хүссэн –14 • Үйл ажиллагаатай холбоотой – 317 • Тэтгэмж хүссэн–40 • Тэмдэг нөхөн олгосон – 19 • Бусад-20
2.	Иргэний нисэхийн ерөнхий газар	Иргэдээс ирсэн нийт 600 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс 97,5 % буюу 585 өргөдөл үйл ажиллагаатай холбоотой, 1 % буюу нь 6 санал хүсэлт, 1,5 % буюу 9 гомдол ирсэн байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Ажилд орох, гарах, чөлөө хүссэн –168 • Үйл ажиллагаатай холбоотой – 181 • Орон сууцны дэмжлэг хүссэн–57 • Сургууль, эмчилгээний тэтгэмж хүссэн-7 • Бусад-122
3.	Нийт	Нийт 1010 өргөдлөөс 1. Өргөдөл 902 /50,1 %/ 2. Санал-хүсэлт -11 /1.085 %/ 3. Гомдол -10 /0,99 %/ 4. Шүүмжлэл -0 5. Талархал, мэдээлэл 0

		1. Үйл ажиллагаатай холбоотой (Авто тээвэр, авто зам, төмөр зам, нисэх) -498 /49,30%/ 2. Сургууль, эмчилгээний зардлын тэтгэмж хүссэн -47 /4,65%/ 3. Ажилд орох, гарах, чөлөө хүссэн - 182 /18,01 % / 4. Орон сууцны үнийн дэмжлэг хүссэн – 57 /5,64%/ 5. Бусад -144 /14,25%/
--	--	---

Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагаас иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийн дагуу Сайд 35, Төрийн нарийн бичгийн дарга 82 иргэнтэй уулзсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яаманд 2016 оны III дугаар улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн 183 өргөдөл, санал, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн 173-д нь хариуг хүргүүлж ажилласан. Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан ирсэн хандалтын шийдвэрлэлт 98.2 хувь, тус яаманд ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 89.0 хувийн биелэлттэй байна.

Бусад төрийн байгууллагаас уламжлан ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна.